

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЗАГВАР, ЗАГВАРЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын баталгаа /цаашид “даатгалын баталгаа” гэх/-ны загвар, түүнийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Даатгалын баталгаа

2.1. Даатгагч гарын үсэг зурсан жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-нд жолоочийн даатгалын мэдээллийн сангаас олгогдож буй гэрээний дугаар нь жолоочийн даатгалын баталгаа болно.

2.2. Даатгагч ~~жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын~~ гэрээг жолоочийн даатгалын мэдээллийн санд бүртгүүлж гэрээний дугаар авна.

2.3. Даатгагч, техникийн хяналтын үзлэг оношлогооны байгууллага, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч ~~жөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч~~, даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч нь цахимаар болон шалгах төхөөрөмж ашиглан даатгуулагчийн даатгалын гэрээг хүчинтэй, даатгалын баталгаатай эсэхийг жолоочийн даатгалын мэдээллийн сангаас шалгана.

2.4. Даатгуулагч нь даатгагчтай болон даатгалын зуучлагч компаниар зуучлуулан хийсэн даатгалын гэрээний баталгаатай эсэхийг жолоочийн даатгалын мэдээллийн сангаас цахимаар хянаж болно.

2.5. Даатгалын гэрээний баталгаатай эсэхийг энэ журмын 2.3, 2.4-т заасан байгууллага, албан тушаалтан жолоочийн даатгалын мэдээллийн сангаас цахим хэлбэрээр хянах боломжийг Албан журмын даатгагчдын холбоо бүрдүүлж өгнө.

Гурав. Даатгалын баталгааны загвар

3.1. ~~Жолоочийн~~ Даатгалын баталгаа нь дараах арван дөрвөн орон бүхий тоон мэдээллийг агуулсан загвартай байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14

3.2. ~~Гэрээний~~ Даатгалын баталгааны дугаарын эхний 2 тоо нь тухайн оны сүүлийн 2 тоог, 3, 4 дүгээр тоо нь Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын компанид олгосон ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаарын сүүлийн 2 тоог, 5-9 дүгээр тоо нь тухайн гэрээг хийсэн даатгагчийн хувийн дугаарыг, 10-13 дугаар тоо нь тухайн даатгагчийн хийсэн, даатгалын зуучлагчийн зуучилсан гэрээний жолоочийн даатгалын санд хугацааны дарааллаар эрэмбэлэгдсэн дэс дугаарыг илэрхийлнэ, 14 дүгээр тоо нь гэрээний төрлийг заана.

3.3. Гэрээний төрлийг заах дугаарлалтын хувьд 1-ийн тоо нь хувь хүн, 2-ын тоо нь аж ахуйн нэгж, 3-ын тоо нь мэргэшсэн жолооч, 4-ийн тоо нь Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх

Жич: *Журамд оруулах өөрчлөлтийг төсөлд тусгахдаа хасагдсаныг дундуур зураасаар, нэмэгдсэнийг доогуур зураасаар тэмдэглэсэн болно.*

болон түр хугацаагаар орж ирж байгаа автотээврийн хэрэгслийг эзэмшигч, өмчлөгчтэй хийсэн гэрээ болохыг тус тус илэрхийлнэ.

Дөрөв. Бусад

4.1. Энэ журмын биелэлтэд Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч нар хяналт тавьж ажиллана.

Жич: *Журамд оруулах өөрчлөлтийг төсөлд тусгахдаа хасагдсаныг дундуур зураасаар, нэмэгдсэнийг доогуур зураасаар тэмдэглэсэн болно.*